

**Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө  
Дорноговь аймгийн Соёл, урлагийн газар**

**2022 оны жилийн эцэс**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>Хоёр. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
1	2.5.9. Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	95. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлэх			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100	ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр БТ 0,378 төгрөг зарцуулсан.	"Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийн нээлтийн үйл ажиллагаанд тус байгууллага нь "Өв соёлоо дээдлэгч монгол хүүхдүүд" уриагаар оролцож, хүүхэд багачуудад шагай наадгай, монгол өв соёл, цагаан идээ зэргийг танилцуулж, өөрсдийн бүтээсэн номын хавчуургыг 150 хүүхдэд бэлэглэсэн. Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийг албан хаагчдын саналыг үндэслэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр СУГ-ын даргын 04 сарын 06-ны өдрийн А/09 дугаар тушаалаар батлуулсан. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хүүхэд хамгаалах бодлогын хүрээнд Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газрын албан хаагчдын 12 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Хүүхдийн эрх, хүүхдийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын тухай мэдлэг олж авахаар гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэнг урьж "Гэр бүлийн төлөвшил, Хүүхэд хамгаалал" сэдвээр сургалт мэдээлэл зохион байгуулсан бөгөөд байгууллагын албан хаагчид 100 хувь хамрагдсан. Хүүхдийн төлөвшил, хүмүүжилд зориулан "Хүүхэд уран зохиол-утга соёл" сэдэвт богино өгүүллэгийн уулзалтыг АЗДТГ, БШУГ-тай хамтран Сайншанд сумын ЕБ-ын ахлах ангийн сурагчдад зохион байгуулсан. Уулзалтад урилгаар МУАЖ Г.Равдан, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч СТА Л.Эрдэнэбат, орчуулгын киноны жүжигчин СТА Ө.Наранбаатар, орчуулгын киноны жүжигчин СТА Т.Энхдөл, "Саран хөхөө" театрын уран бүтээлчид оролцон зохиолч Ж.Лхагваа агсны 450 сурагч хамрагдсан. Зэвсэгт хүчний 101 жилийн ойд зориулан ЕБС-ийн сурагчдын дунд "Монгол цэрэг" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж бүтээлээ ирүүлсэн 27 хүүхдээс шилдгүүдийг шалгаруулан урамшууллаа.Эх үрсийн баяраар "Баатруудын адал явдал" хүүхдэд зориулсан жүжгийг шинэчлэн найруулж, 1300 гаруй хүүхдэд үнэ төлбөргүй толилууллаа. Аймгийн Засаг даргын А/249 дүгээр захирамжаар батлагдсан "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээнд аймгийн Соёл, Урлагийн газар 5 дугаар сургуулийн 5-7 дугаар ангийн 47 хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулж тэднийг сонсож гарын бэлэг гардууллаа.Саран Хөхөө театр 6 шинэ уран бүтээл туурвилаа.	100%
2	2.6.1.	97.			Гүйцэтгэ	УТ-1 тэрбум 800	Сайншанд суманд 700 хүний суудалтай "Саран Хөхөө" шинэ театрын барилга	70%

	“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Үндэсний бахархал, монгол	Сайншанд суманд 700 хүний суудалтай “Саран Хөхөө” шинэ театрын барилга барих			-лийн хувь 80	сая	барих ажлыг “Болор аграмба” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын газар шороо, суурь, булагдах хэсгийн хийцлэлийг хар тосон түрхлэг түрхэх, шороо эргүүлэн булж, нягтруулах, хар шалны ажлууд нь хийгдэж дууссан. Зоорийн давхрын каркасан хийц угсрагдаж бүрэн дуусаад тайзны хэсгийн багана дам нурууны угсралт, хөгжимчдийн хэсгийн дам нурууны угсралт зэрэг ажлууд хийгдэж байна. Саран Хөхөө театрын барилгын явцтай Төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн , ХШҮ хариуцсан мэргэжилтэн нар Газрын харилцаа барилга хот байгуулалтын мэргэжилтэнтэй хамтран танилцсан. Нийт ажлын явц 50 хувьтай байна.	
3	соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн соёл урлагийн	98. Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёлын ордон барих			Гүйцэтгэлийн хувь 80	УТ- 1 тэрбум 800 сая	Замын-Үүд суманд 500 хүний суудалтай Соёлын ордон барих ажлыг “РСТ” ХХК гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын аяган суурийн угсралт, В, М, К, 13, 23-р тэнхлэг дагуух цутгамал төмөр бетон ханын угсралт, зоорины давхрын бетон шал, хучилт, шатны угсралт, тосон түрхлэг, шороогоор нягтруулах ажил бүрэн хийгдэж, барилгын каркасан хийцийн ажил нь бүрэн дууссан. Хүйтний улирал эхэлсэн тул барилга угсралтын ажилд технологийн зогсолт хийсэн . Нийт ажлын явц 45 хувьтай.	50%
4	байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	99. Сайншанд сумын 5-р багийн соёлын ордны дээврийн засвар хийх			Гүйцэтгэлийн хувь 100%	177,3 сая	Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газраас ДГАОНӨГ/202212017 дугаартай уг ажлыг гүйцэтгэх нээлттэй тендэрийг 2022 оны 03 сарын 07-ны өдөр зарласан ба гүйцэтгэгчээр “Мөнх хархираа” компани шалгарсан. Зүүнбаян багийн Соёлын төв ордны дээврийн ажил нь 6-р сарын 04-ний өдрөөс эхэлж хийгдсэн бөгөөд засварын ажил бүрэн дуусч Улсын комисс 2022 оны 09-р сарын 15-ны өдөр газар дээр ажиллан ашиглалтад хүлээж авсан.	100%
5	2.6.2. Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	101. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх			Шинээр цахим үйлчилгээ нэвтрүүлэх байгуулла-гын тоо 2	Замын-үүд Соёл, спортын төв Орон нутгийн төсвөөс 2.0 сая, байгууллагын төсвөөс 2.0 сая нийт 4.0 төгрөг зарцуулсан. Аймгийн засаг дарга Төв номын сангийн Үүлэн серверт 2.7 сая төгрөг	Соёлын яамтай хамтран аймгийн Соёл, урлагийн газар вэб сайт шинээр нээлээ. Шинээр цахим үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд Хатанбулаг сумын орон нутгийн музейн 54 үзмэрийг 3D төлөвт зурагжуулан соёлын шинэ үйлчилгээг бий болголоо. Үзмэрийг 3D төлөвт зурагжуулахад 1.5 сая төгрөг зарцуулсан. Замын-үүд сумын Соёл, спортын ордон өндөр хурдны интернэт суурилуулж номын сандаа шинээр 10 ширхэг суурин компьютерийг байрлуулж иргэд, залуучуудын эрэлт хэрэгцээг ханган орон нутгийн төсвөөс 2.0 сая , байгууллагын төсвөөс 2.0 сая нийт 4.0 төгрөг зарцуулсан. Энэ онд сумдын Соёл, спортын төвтэй хамтран Музей сургалт судалгааны төвийн үзүүлэлийн 6 танхимд байршуулсан үзмэрүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг Google meeting аппликэйшнийг ашиглан Мандах, Сайхандулаан, Иххэт сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 160 сурагчдад онлайнаар үзүүлээ. Аймгийн төв номын сангийн уншлага үйлчилгээнд "Үүлэн сервер" шинэ цахим технологийг нэвтрүүлэн ОНТ-өөс 2,7 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг	100%

					зарцуулсан. Хатанбулаг сумын музей 3D үзмэрт малчдын хандиваар 1.5 сая төгрөг зарцуулсан.	шийдүүлээ. Номын сангийн "Үүлэн сервер" электрон каталогийг ашиглах заавар зөвлөмжийг ил байршуулан, хайлтын компьютероор үйлчилж байна. Цахим каталогиос уншигчдад хэрэгцээт ном хэвлэлийг түргэн шуурхай эрэн хайх, цахим лавлагаа мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээ үзүүлж, шинэ 280 номыг цахим санд бүртгэн электрон каталоги болгож, цахимаар гэрээр олгох танхимын 7815, Үндсэн фондын 17588 номыг цахимаар тооллоо. Төв номын сангийн дэргэдэх "Америкийн соёл мэдээллий төв " нь АНУ-ын ЭСЯ-ны 63,0 сая, Орон нутгийн төсвийн 12,0 сая төгрөгийн санхүүжилтээр дотоод засал, техникийн шинэчлэл хийлээ.	
6	102. Соёл урлагийн байгууллага, сургууль цэцэрлэгийн дуу хөгжмийн багш, мэргэжлийн уран бүтээлчдийг сургаж бэлтгэх			Шинээр дэмжлэг үзүүлэх багш, уран бүтээлчдийн тоо 3	Эчнээ сургалтанд Аймгийн Засаг даргын А/280 захирамжаар нийт 5,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн уран бүтээлчдийг сургах сургалтад СУГ-аас 3,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. СУГ-аас 1,0 сая төгрөг Нийт 10,0 сая төгрөг	2022 онд Аймгийн Засаг даргын А/280 захирамжаар Саран Хөхөө театрын хөгжимчин А.Энхнаран, бүжигчин Б.Мөнхжин, С.Мягмарсүрэн нарыг Сити дээд сургуулийн эчнээ сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгааг дэмжин сургалтын төлбөрт 5,0 сая төгрөгийг шийдлээ. 2019-2023 он хүртэлх хугацаанд Дорноговь аймаг СУИС-тай хамтран ажиллах ажлын хүрээнд хөгжмийн урлагийн сургуульд суралцаж буй оюутнуудын төлбөрийг үргэлжлүүлэн төлсөн бол Соёл, урлагийн газраас 2022-2023 оны хичээлийн жилд ЭЕШ-ын босго оноог давсан авьяас, ур чадвартай 7 суралцагчийг нэмэлт шалгалтгүйгээр Дүрслэх урлагийн академид элсүүлэн сургах зорилгоор суралцах эрх болон урилгыг ЕБС-ын 12 анги төгсөгчдөөс 7 хүүхдэд гардуулан өглөө. Саран Хөхөө театрын санаачилгаар мэргэжлийн 1 морин хуурчийг театрт урьж ажлуулж, туршлага солилцсон. Мөнгөн хараа чуулгийн бүжиг дэглээч, бүжигчин О.Ууганбаяр Саран хөхөө театрын бүжигчдэд шинэ бүжиг дэглэн өгч театрын урын санг баяжууллаа. Саран хөхөө театрт цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучин Б.Батбаатар, чуулгийн Концертмейстер Г.Батнасан нар 3 хоногийн турш ажлын байран дээрх мэргэшүүлэх сургалтыг орлоо. Сургалтад дуучид, бүжигчид, хөгжимчид нийлсэн 35 уран бүтээлч хамрагдсан. СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн тайзны ярианы багш Р.Нацагдоо театрын драм ангийн 6 жүжигчинд 5 хоногийн турш жүжиглэх урлаг, тайзны ярианы хичээл орлоо. Соёл, урлагийн газраас чиглэл өгч дадлага болон онолыг хослуулсан 2 хэлбэртэй сургалтыг 1 сарын хугацаанд Даланжаргалан сумын Соёлын төвийн дарга Б.Ганболд, Саран Хөхөө театрын хөгжмийн багш Л.Батболд нартай хамтран сумдын хөгжмийн багш нар 12 хүнийг хамран зохион байгууллаа.	90%
7	103. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд шинэлэг арга			Арга хэмжээ, үйлчилгээ авах иргэдийн тоо 35/68000	Язгуур алтан өв-ОНТ 20 сая "My story" кино контент- ОНТ 10 сая	Аймгийн МССТ-ийн үзмэрийг цахим хэлбэрээр үзүүлэх ажлыг сумдын Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран хэрэгжүүлж 2300 хүүхдийг хамрууллаа. Соён гэгээрүүлэх чиглэлээр музейн үзэсгэлэн, ховор хуучин ном, шинэ номын үзэсгэлэн зэргийг сумдын соёлын төвүүдтэй хамтран үйлчилгээг шинэлэг хэлбэрээр 1800 иргэдэд үзүүлээ. Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран "Соёлтой жолооч" аяны хүрээнд 8 төрлийн видео контентийг бэлтгэн 14,0 мянган хүнд түгээлээ. Түүнчлэн аймгийн DTV телевизтэй хамтран	90%

		барилыг нэвтрүүлж хүртээмжийг сайжруулах				нэвтрүүлэг бэлтгэн, хүүхэд багачууддаа үлгэр дууриалал болж соёлтой зорчигч, соёлтой жолооч байхыг уриалсан нөлөөллийн ажлыг зохион байгууллаа. "Язгуур алтан өв" соёлын биет бус өвийн наадамд 14 сумын 321 өвлөн уламжлагч оролцсон бөгөөд өвлөн уламжлагчдыг алдаршуулах, эзэмшсэн өвийг олон нийтэд түгээх зорилгоор D МЕДИА агентлагтай хамтран "Язгуур алтан өв"-ийн CD гаргаж, 350 ширхэг ном хэвлүүлсэн.наадмыг LIVE- аар шууд дамжуулж, 5000 гаруй иргэн ирж үзэж, байгууллагын пэйж хуудсанд байршуулсан бичлэгийг 10,000 гаруй хүн үзсэн байна. Дорноговийн уран бүтээлчдийн хамтарсан А.Баярсайханы зохиол "My story" кино контент аймгийн кино театрт нээлтээ хийснээр IP телевизүүдээр цацагдан олны хүртээл болсноос гадна Ардын уран зохиолч Б.Догмидын зохиол "Их талын хүн чулуу" шагайн өв соёлыг харуулсан үндэсний хэмжээний контентийг бүтээн youtube-д байршуулж 641 хүн үзсэн ба Монголын үндэсний телевизийн оргил цагаар 3 удаа цацагдлаа. Цахим орчинд соёлын салбарын 151 үйлчилгээг 51,735 иргэнд хүргэж ажилласан.	
8	2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	104. Баяр наадам, тэмдэглэлтэй, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжиж ажиллах		Дэмжлэг үзүүлэх арга хэмжээний тоо 5	<p>"Сар шинийн баярыг тохиолдуулан А.Баярсайханы зохиол "Азын бууз" кино контент шинээр хийх төслийг дэмжин уламжилж Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10,0 сая төгрөг шийдвэрлүүлсэн, "Язгуур алтан өв"анхдугаар үзлэг наадамд ОНТ 20,0 сая төгрөг шийдсэн. "Нүүдэлчин Монгол-2022" соёлын фестиваль ОНТ 30,0 сая төгрөг.</p> <p>Тайлант онд уламжлалт "Сар шинийн баярыг тохиолдуулан А.Баярсайханы зохиол "Азын бууз" кино контент шинээр хийх төслийг дэмжин уламжилж ОНТ-өөс 10,0 сая төгрөг шийдвэрлүүлсэн 04 сард "Соёл урлагаа дээдлэн дэмжицгээе" сарын аяныг зарлан нээлтийн үйл ажиллагаанд агентлагийн удирдлагуудыг оролцуулан зохион байгууллаа. "Театрт тавтай морил-1" хавар, намрын аянаар 14 уран бүтээлийг цувралаар хүргэн толилууллаа. "Монгол цэргийн өдөр" буюу Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баяраар ""Монгол цэрэг"" гар зургийн уралдааныг ЕБС-иудын дунд ангийн сурагчдын дунд, Насан туршийн боловсролын төвтэй хамтран ""Олон улсын эх хэлний өдөр""-ийг тохиолдуулан "Уран тайлбар хийх" уралдаан зэргийг зарлан дүгнэлээ. Соёл урлагийн газраас "Соёл, урлагийн ажилтны өдөр"-өөр "Соёлын орон зай" зөвлөгөөнийг 09 дүгээр сард зохион байгуулж 200 гаран соёлын ажилтан хамрагдлаа.05 сард Аймгийн СББӨ-ийн "Язгуур алтан өв" анхдугаар үзлэг наадмыг МССТ, 14 сумын Соёлын төвүүдтэйгээ хамтран 372 өвлөн уламжлагчдыг оролцуулан СББӨ-ийн 7 ай савын хүрээнд зохион байгууллаа. Мөн Соёлын яам, ЗГХА Соёл урлагийн газар, Соёлын өвийн Үндэсний төвөөс зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестиваль 08 сард зохион байгуулагдаж, тус наадамд АЗДТГ, СУГ, МССТ, "Саран хөхөө" театр хамтран СББӨ-ийг түгээн дэлгэрүүлж буй шавь сургалтын 5 багш, 5 суралцагч, соёлын бүтээлч үйлдвэрлэгчид, тогоочдын холбоо болон СББӨ-ийн 7 ай савын 55 төрлөөр нийт 61 өвлөн уламжлагч, 27 зохион байгуулагчид нийт 88 хүний бүрэлдэхүүнтэйгээр гар урлалын 50 гаруй бүтээлийг дэглэн оролцож гутгаар байр эзэлсэн. Аймгийн баяр наадамд зориулан СББӨ-ийг өвлөн уламжлагч 19 хүний бүрэлдэхүүнтэй "Нүүдэлчин хөг" тоглолт, Саран хөхөө театртэй хамтран "Цэнгэлтэй үдэш" үдшийн цэнгүүнийг зохион байгуулсан. Хүндэтгэлийн тоглолтыг "Саран Хөхөө" театр болон</p>	100%	

					“Соёл, урлагийн ажилтны өдөр”-өөр "Соёлын орон зай" зөвлөгөөнд 10 сая төгрөгийг зарцуулан 200 гаруй уран бүтээлч хамрагдсан.Нийт 50,0 сая төгрөг	Улаанбаатар дахь уран бүтээлчдийн төлөөлөл оролцон 600 хүнд толилууллаа.Нээлтийн үйл ажиллагааг хийлээ.“Хутагтын шүншигтэй аялгуу” уран бүтээлийн цэнгүүн зэрэгт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.	
9	105. Хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл туурвих			Уран бүтээлийн тоо 3	Соёлын яам, БТ-Шүдний аялал” хүүхдийн жүжиг 1,2 сая төгрөг “Мангасуудын хаан” хүүхдийн жүжиг 4,0 сая төгрөг, “Хөхөө хүү-Саран охин” хүүхдийн жүжигт 30,0сая төгрөг “Гэрэл асаа” ёс зүйн шоу драмд 5,4 сая төгрөг нийт 40,6 сая төгрөг	“Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд “Саран хөхөө” театр нь “Монгол улсын хүүхэлдэйн театр”-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж ,санамж бичгийн хүрээнд Дорноговь аймагт хүүхэлдэйн урлагийг хөгжүүлэх, цаашлаад хүүхэлдэйн театрын салбарыг байгуулах, хүүхэлдэйн урлагийн талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай анхан шатны хэрэглэгдэхүүнээр ханган ажиллахаар болсон. Энэ хүрээнд “Бяцхан хатагтайн хүүхэлдэйн театр” хүүхэлдэйн концертыг хүүхэд багачуудад толилууллаа. “Саран хөхөө” театр нь МУ-н Хүүхэлдэйн театрын албан ёсны эрхтэйгээр “Могжоохон даагатай-Жогжоохон хүү”, Н.Мандалын зохиол “Шүдний аялал” хүүхэлдэйн жүжгийг 05,11 саруудад Саран хөхөө театрын үзвэрийн танхимд, Сайншанд сумын Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгүүдийн урлаг зааланд, Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургууль, Соёл спортын ордон, Үлэмж тэнгэр ерөнхий боловсролын сургуульд сонирхуулан амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн 50 хүүхдийг үнэ төлбөргүй тоглолт үзүүллээ. “Могжоохон даагатай - Жогжоохон хүү” хүүхэлдэйн жүжгийг Дорноговь аймгийн хэмжээнд нийт 1486 хүүхэд багачуудад тоглосон бөгөөд 7,180,000 төгрөгний орлогыг өөрийн орлогод төвлөрүүллээ, Хүүхэд хөгжил-2022 зорилтот жилийн хүрээнд Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Саран хөхөө театрын найруулагч А.Баярсайханы зохиол “Баатруудын адал явдал” сэдэвт хүүхдэд зориулсан жүжгийг 2 өдрийн турш 4 удаа тоглож 1300 хүүхдэд үнэ төлбөргүй хүргэлээ, Дорнод аймгийн “Хөгжимт драмын театр”-тай хамтын ажиллагааны хүрээнд Б.Мөнх-Амьдралын зохиол “Мангасуудын хаан” хүүхдийн жүжгийн Саран хөхөө театрын тайзнаа 3 өдрийн турш 9 удаа тоглосон, Н.Мандалын зохиол Саран хөхөө театрын найруулагч А.Баярсайханы найруулга "Саран охин-Хөхөө хүү"-гийн адал явдал" танин мэдэхүйн хүүхдийн жүжиг, "Гэрэл асаа" ёс зүйн шоу драм өсвөр үеийнхэнд зориулсан жүжиг нийт 6 жүжгийг хүүхэд багачууддаа хүргэлээ.	100%
10	106.			Зохион	“Бүдэг гэрлийн	Соёл урлагийн газар, Аймгийн музей, сургалт судалгааны төв, Төв номын	100%

		Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах			байгуулах арга хэмжээний тоо 4	нөмрөг дор” үдшийн уншлага 0,3 сая төгрөгийг хувь хүн ивээн тэтгэсэн .”Борхойн цом” яруу найргийн наадмыг Замын-үүд сумын Иргэдийн хурлаас 3,5 сая төгрөгийн хөрөнгийг шийдсэн. Ж.Лхагваагийн “80 насны ойд зориулан “Яруу найраг” наадамд УТ,ОНТ-өөс 2 сая төгрөг. Замын-Үүд сумын ЗДТГ -5,0 сая төгрөг Нийт 10,800,0 төгрөг	сан, Дэлгэрэх, Алтанширээ, Айраг, Замын-Үүд, Хөвсгөл, Иххэт, Даланжаргалан, Мандах сумдын Соёлын төв, Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төв, СГЗ А.Эрдэнэ-Очир сан зэрэг байгууллагууд хамтран Санхүүгийн хяналтын бүсчилсэн сургалтын хүрээнд болон бие даасан байдлаар хайрын шүлгийн “Оюу ай”, зохиолч, яруу найрагч Содномдоржийн дурсгалд зориулсан шүлгийн наадам, СГЗ А.Эрдэнэ-Очирын нэрэмжит “Бүдэг гэрлийн нөмрөг дор” үдшийн уншлага, “Борхойн цом” яруу найргийн наадам, МУСТА зохиолч, яруу найрагч, сийлбэрч, зураач Б.Цэрэннадмидын уран бүтээлийг алдаршуулах, сурталчлах зорилгоор “Ярууслын чимээ” яруу найргийн тэмцээн, Айраг сумын ардын авьяастнуудын дунд зарласан “Энэрлийн бүүвэйтэй хорвоо”, “Дуэт дуэль” уралдаануудыг зохион байгууллаа. СТА П.Үрэлцэцэг тэргүүтэй ардын авьяастнуудын хамтарсан “Ардын дуу-3” бие даасан тоглолтыг бүх сумдад тоглоход Соёлын төвүүд дэмжлэг үзүүллээ. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх мөн “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 3 сумын соёлын спортын төвөөс “Авьяаслаг Өргөнчүүд” “Авьяаслаг Мандахчууд” “Авьяаслаг Дэлгэрэхчүүд” урлаг соёлын наадам, Алтанширээ, Эрдэнэ, Өргөн, Хатанбулаг сумын Соёл спортын төвөөс нутгийн ардын авьяастнуудын дунд “Баруун бүсийн болон Сумын Манлай дуучин” зэрэг 7 сумын соёл, урлагийн арга хэмжээнд чиглэл өгч дэмжин ажиллаа, Иххэт ,Алтанширээ сумын соёлын төвийн ардын авьяастнуудын хамтарсан “Аялгуу өвлөгдсөн алтан хөршүүд” тоглолтыг 2 сумын нийт 260 үзэгчдэд хүргэн ажилласнаас гадна нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдыг алдаршуулах, уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх “Хутагтын шүншигтэй аялгуу” дуун цэнгүүнд 2 сая төгрөгөөр дэмжлэг үзүүллээ Сайншанд COVER болон “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан МУГЖ.Н.Лантуу МУСТА Ч.Цэрэндэжид нартай хамтран нутгийн ардын дууг зааж сургах ажлыг санаачлан зохион байгууллаа.	
11	2.6.4. Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, судлан сэргээх, өвлөн уламжлуу	107. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн,			Цахим сан-2 Урамшуулах хүний тоо-20	Аймгийн Засаг даргын 2022 оны А/ 279-р захирамжаар ОНТ 20.0 сая төгрөг шийдвэрлэсэн. "Нүүдэлчин Монгол-2022" улсын үзлэг наадамд 30,0 сая төгрөг	2022 оны 5-р сард зохион байгуулсан “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадмын хүрээнд Соёл, урлагийн газраас “D media” агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулан өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн, өвлүүлэн үлдээх зорилгоор шилдэг өвлөн уламжлагчийг оролцуулсан нэвтрүүлэг, тоглолтын бичлэг болон 14 сум тус бүрийн тоглолтын бичлэгийг олшруулж, “Язгуур алтан өв” ном-350 ш, DVD-250 ш хийж баримтжууллаа. Өвлөн уламжлагч 17 хүний бие даасан нэвтрүүлгийг DTV тэй бэлтгэж цахим сан үүсгэн аймгийн 90 жилийн ойн баяр наадмаар улсын хэмжээнд юнивишний 963, DDISH 941-р сувгаар давтамжтай нэвтрүүлэн сурталчиллаа. Мөн “Язгуур алтан өв” наадмыг LIVE- аар шууд дамжуулж, 5000 гаруй иргэн ирж үзэж, байгууллагын пэйж хуудсанд байршуулсан бичлэгийг 10,000 гаруй хүн үзсэн байна. “Нүүдэлчин Монгол-2022”	90%

	лах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.	өвлүүлэн үлдээхэд урамшуулах			шийдвэрлэсэн. БТ-Соёл, урлагийн газраас "Дорноговь судлал" эрдэм шинжилгээний хуралд-2,0 сая Нийт 52,0 сая төгрөг.	дэлхийн соёлын фестивалд 7 ай савын 61 өвлөн уламжлагчийн бүрэлдэхүүнтэй оролцож, 636 оноогоор "Гутгаар" байранд орсон амжилт үзүүлээ. Наадамд оролцож буй тухай телевизүүд аймаг, аймгийг хариуцан бичлэг бэлтгэсэн ба манай аймгийг UBS телевиз хариуцан, өвлөн уламжлагчдын 1 цагийн нэвтрүүлгийг хамтран бэлтгэж энэ оны 8-9 дүгээр саруудад өөрийн сувгаар 4 удаагийн давтамжтай орон даяар олон нийтэд түгээлээ. UBS телевизийн бие даасан нэвтрүүлгийг аймгийн архив болон, Музей, сургалт судалгааны төвийн цахим санд хүлээн авлаа.Нэвтрүүлэг болон аймаг, улсын хэмжээний арга хэмжээнд шалгарсан 66 өвлөн уламжлагчдыг 12400,0 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.СУГ, МССТ хамтран "Соёлын бүтээлч сар"-аар баримтат өвийн үзэсгэлэн, бүтээлч үйлдвэрлэгч нарын үзэсгэлэн- худалдаа, "Дорноговь судлал" танин мэдэхүйн илтгэл, Алтанширээ сумын ОНСМ-ийн шинэчлэлийг зохион байгууллаа.Үндэсний агуулгатай видео бичлэгийн тоо - 2 "Нүүдэлчин Монгол" Соёлын биет бус өвийн фестивалд оролцсон өвлөн уламжлагчдын видео бичлэгийг UBS телевизтэй хамтран дүрсжүүлж, тус телевизээр 4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд хүргэлээ.	
12		108. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тоглолт арга хэмжээ зохион байгуулах			Аймгийн Засаг даргын 2022 оны А/ 279-р захирамжаар ОНТ 20.0 сая төгрөг шийдвэрлэсэн." Нүүдэлчин Монгол-2022" улсын үзлэг наадамд 30,0 сая төгрөг шийдвэрлэсэн. Нийт 50,0 сая төгрөг.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/279 дүгээр захирамжаар соёлын биет бус өвийн "Язгуур алтан өв" аймгийн анхдугаар наадмыг 2022 оны 05 дугаар сарын 17-18ны өдрүүдэд Соёлын өвийн үндэсний төв, эрдэмтэн судлаачдыг урин оролцуулж зохион байгуулж, 7 ай савын хүрээнд 14 сумын 372 өвлөн уламжлагч оролцлоо. Сум тус бүр өөрсдийн онцлогийг харуулсан монгол гэрт биет өвийн үзэсгэлэн байршуулж, төв талбайд зассан тайзнаа хуваарийн дагуу биет бус өвийн 14 тоглолт сонирхуулсныг ,биет бус өвийн 7 ай сав бүрээс нийт 31 өвлөн уламжлагчийг шалгаруулан мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Аймгийн "D media" агентлаг, СУГ хамтран ажиллах гэрээ байгуулан өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн, өвлүүлэн үлдээх зорилгоор шилдэг өвлөн уламжлагчийг оролцуулсан нэвтрүүлэг, тоглолтын бичлэг болон 14 сум тус бүрийн тоглолтын бичлэгийг хувилах ажлуудыг зохион байгуулж "Язгуур алтан өв" ном-300 ш, DVD-250 ш хэвлүүлэн баримтжууллаа. Мөн "Язгуур алтан өв" наадмыг LIVE- аар шууд дамжуулж, 5000 гаруй иргэн ирж үзэж, байгууллагын пэйж хуудсанд байршуулсан бичлэгийг 10,000 гаруй хүн үзсэн байна. "Язгуур алтан өв" соёлын биет бус өвийн үзлэг наадамд 7 ай савын хүрээнд амжилттай оролцсон нийлбэр дүнгээр тусгай байрыг Сайншанд, гутгаар байрыг Эрдэнэ, дэд байрыг Замын-Үүд, тэргүүн байрыг Дэлгэрэх сум эзэллээ. Өвлөн уламжлагчдын зөвлөгөөнийг зохион байгуулснаас гадна шилдэг өвлөн уламжлагчдын гала тоглолтыг зохион байгуулснаараа энэ удаагийн арга хэмжээ оролцогчдын болоод иргэдийн талархлыг хүлээсэн өвөрмөц, сумд байгууллагуудад үлгэр болохуйц соёлын өвөөрөө бахархах үзэл санааг сэргээсэн нөлөөллийн том ажил боллоо гэж дүгнэж байна. Аймаг байгуулагдсаны 90,91 жилийн ойг тэмдэглэн	100%

						өнгөрүүлэх хөтөлбөрт "Нүүдэлчин хөг" шилдэг өвлөн уламжлагчдын тоглолтыг оруулан гэр бүлийн талбайд тоглуулан 1500 хүнд сонирхуулснаас гадна Улаанбаатар хотноо өөрийн аймгаа сурталчилан отгийн гадаа болон тоглолтын гэрт 6 удаагийн тоглолт хийн 4000 хүнд сонирхууллаа.	
13		109. Музейн сан хөмрөгийг баяжуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах		Сан хөмрөгийн баяжилт 15, Бүртгэлжүүлсэн үл хөдлөх дурсгалт газрын тоо 10	Соёлын яам 10,0 сая төгрөг ОНТ 2022 оны А/566 р захирамжаар 4,700,000 төгрөг. СУГ-ын даргын А/28 тушаалаар 5,000,000 төгрөг нийт 19,7 сая төгрөг	Аймгийн МССТ-ийн сан хөмрөгт "Бургасан ханатай гэр"- 1 дэсийн 1 ширхэг үзмэрийг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр худалдан авч, дотоод тавилга эд хогшлыг нөөц бололцоогоо ашиглан иж бүрэн болголоо Мөн Ардын хувьсгалын партизан Д.Сүхээгийн шагнал болох 1 дэсийн 13 ширхэг одон медалийг үр хүүхдүүдээс нь музейн сан хөмрөгт бэлэглэснийг бүртгэлжүүлж, нийт 14 ширхэг үзмэрээр сан хөмрөгийг баяжуулсан.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2022 оны А/566 дугаар захирамжаар байгуулагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2022 оны 09-р сарын 14-нөөс эхлэн 2022 оны 2022 оны 10-р сарын 23-ны хооронд 1 сар гаруй хоногийн хугацаанд чанартай сайн гүйцэтгэлээ. 5 жилд нэг удаа зохион байгуулагддаг энэхүү улсын тооллогоор Дорноговь аймгийн 13 сумын нутаг дэвсгэрт байгаа 415 байршилд буюу дурсгалт газар орших 2500 гаруй үл хөдлөх дурсгалуудыг бүрэн хамруулан, тооллогын журам, судалгаа шинжилгээний аргачлалын дагуу гэрэл зургаар баримтжуулан, мэргэжлийн хэмжих багаж тоног төхөөрөмжөөр газар зүйн байршлыг тогтоон rich.mongol.uv.mn программд мэдээллийг оруулсан. 2022 оны энэхүү улсын ээлжит тооллого нь 2015 оны улсын тооллого, 2021 онд хийгдсэн хэсэгчилсэн тооллогоор бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтыг баталгаажуулан үзэж, харьцуулсан гэрэл зургаар баримтжуулан эвдрэл гэмтэл, аж ахуйн нөлөөнд автсан эсэхийг нягтлан тодруулж улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд мэдээллийг шинэчлэн оруулснаараа ач холбогдолтой боллоо. Сумдын Засаг дарга, байгаль орчны байцаагч нарын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, үл хөдлөх дурсгалуудыг иргэд малчдад гэрээгээр хариуцуулах, соёлын өвийн ажилтнуудын идэвх санаачилгыг өндөржүүлэх сургалт мэдээлэл солилцох ажлууд давхар хийгдлээ. Тооллогын нэгдсэн дүн, тайлан мэдээг Соёлын өвийн үндэсний төв болон аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллалаа.	90%
14		110. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалы	Зохион байгуулах арга хэмжээн ий тоо, хамрагдах өрх 70/1900	Сургагч багшийн урамшуулал БТ 0,3 сая төгрөг	Угийн бичиг хөтлөх аргачлалын сургалтыг сургагч багш Ч.Өлзийжаргалтай хамтран Аймгийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Сайншанд сумын ЗДТГ зэрэг 9 байгууллагын ажилтан албан хаагчид болон соёлын байгууллагуудын ажилтнууд, Насан туршийн боловсрол төвтэй хамтран цахим хэлбэрээр заан танхим болон цахимаар 218 иргэнд мэдээлэл өглөө. Замын-Үүд, Даланжаргалан, Иххэт, Улаанбадрах, Алтанширээ, Дэлгэрэх, Хатанбулаг сумдын музейн ажилтнууд,	90%	



		г хэвшүүлэх зан үйлийг сургах, сургалт нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх					Насан туршийн боловсролын сургагч багш нартай хамтран угийн бичгийн цахим болон танхимын сургалтыг 210 иргэнд хүргэснээр нийт 428 хүнийг хамрууллаа. Түүнчлэн соёлын бүтээлч сар аяны хүрээнд Эрдэнэ, Хатанбулаг, Сайхандулаан, сумдууд угийн бичгийн сургалтад 250 сурагчдыг хамрууллаа. Хөвсгөл сумын Соёл, спортын төвөөс санаачлан хөдөөгийн 2 багт угийн бичгийн сургалт, тэмцээн, шилдэг угийн бичиг хөтөлсөн өрх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 40 өрхийн 140 иргэнд угийн бичгийн анхан шатны ойлголт боловсролыг олголоо. Музей сургалт судалгааны төвийн тайлбарлагч, боловсролын ажилтан Б.Болорчимэг Аймгийн татварын хэлтэс болон Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 25 албан хаагчид угийн бичгийн сургалт зохион байгуулж анхан шатны мэдлэг олгосон. Иххэт сумын музейн ажилтан Ж.Сарантуяа "Бүтээлч сар" аяны хүрээнд Даланжаргалан, Айраг сумдын иргэдэд нүүдлийн музейгээр үйлчилж, 2 сумын 86 иргэн, мөн сумын 3 багийн 6 өрхөд угийн бичгийн сургалтыг хүргэлээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх хүн судлалын үндэсний төвийн ЭША доктор Э.Энхмаагийн youtube д байршуулсан цахим цуврал хичээлүүдийг ашиглан олон нийтийн ойлголтыг нэмэгдүүллээ. Аймгийн хэмжээнд сүм хийд болон иргэдийн гар дээр байгаа ховор хуучин ном судар зэрэг баримтат өвийг бүртгэх явцдаа айл өрхүүдийн угийн бичгийн эмхэтгэсэн 46 ш номыг баримтат өвөөр бүртгэн мэдээллийн санд орууллаа.	
<b>Гурав. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>								
15	3.1.2. Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулах бодлого баримтална.	116. Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулах			Зардлын хэмнэлтийн хувь 4.5	Улсын төсвөөс нийт 3 тэрбум 266,3 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 96,7 сая төгрөг	Соёлын сайдаас 2022 оны эхэнд Дорноговь аймгийн соёл, урлагийн салбарт нийт 2 тэрбум 913 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан. Жилийн явцад 100,9 сая төгрөг нэмж хуваарилсан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 2 тэрбум 831 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулан ажиллалаа. Соёл урлагийн газарт Улсын төсвөөс 252,4 сая төгрөгийн санхүүжилтийг, орон нутгийн төсвөөс 96,7 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулан ажилласан. Тайлант хугацаанд өөрийн харьяаны 9 байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 2021 оны Төсвийн хэмнэлтийн тухай ЗГ-ын 388 дугаар тогтоол, 2022 оны Төсвийн хэмнэлтийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсөн.	100%
<b>Дөрөв. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>								
16	4.1.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр	178. Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг			Шинээр цахим систем нэвтрүүлэх	Замын-үүд сумын Соёл, спортын ордон Орон нутгийн төсвөөс 2.0 сая,	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газраас бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP систем"-ийг ашиглаж, аймгийн Соёл, урлагийн газрын 10 албан хаагч, салбарын буюу Музей сургалт, судалгааны төв /15/, Аймгийн Төв номын сан /9/, Саран хөхөө театр /9/, сумдын Соёлын төвийн	100%

	дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим хэрэгслийг нэвтрүүлнэ.	үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулах			байгуулла-гын тоо 28	байгууллагын төсвөөс 2.0 сая нийт 4.0 төгрөг зарцуулсан. Хатанбулаг сумын Соёл, спортын төвийн орон нутгийн музейд малчид 1.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн. Төв номын сан "Үүлэн сервер" программыг ашиглах 2,7 сая төгрөгийг ОНТ-өөс шийдүүллээ.	19 албан хаагч нэвтрүүлж салбарын хэмжээнд 62 албан хаагчид албан ажилдаа хэрэглэж байна. ERP системын сургалтад соёлын салбарын 37 албан хаагч хамрагдаж ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаврын биелэлт, төрийн үйлчилгээг иргэдэд хэрхэн үзүүлэх талаарх мэдээллийг олж авсан. Төрийн байгууллагын үндэсний цахим шуудан ашиглахтай холбогдуулан үндэсний дата төв рүү хүсэлт илгээж домайн хаяг үүсгүүлж байгууллагын 10 албан хаагчдад албаны и-мэйл хаяг нээсэн. Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг оруулаад байна.Салбарын ХШҮ-ний moc.igovernment.mn мэдээллийн цахим сан, Дорноговь аймгийн ХШҮ-ний dornogovi.unelgee.gov.mn сангуудыг албан хаагчид үйл ажиллагаандаа ашиглаж, тайлагнаж байна.Мөн Хатанбулаг сумын Соёл, спортын төв орон нутаг судлалын музейн 54 үзмэрээ 3D хэлбэрт шилжүүлэн нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлүүллээ. Музейн үзмэрээ 3D хэлбэрт шилжүүлсэн нь музейн салбарт шинэ өнгө төрхийг бий болгож, шинэ үйлчилгээ, шинэ соёлыг түгээх эхлэл болсон. Замын-үүд сумын Соёл, спортын ордон өндөр хурдны интернэт суурилуулж номын сандаа шинээр 10 ширхэг суурин компьютерийг байрлуулж иргэд, залуучуудын эрэлт хэрэгцээг ханган ажиллалаа. Аймгийн төв номын сан уншлага үйлчилгээндээ "Үүлэн сервер" технологийг ашиглахаар хөрөнгийн асуудлыг шийдүүллээ.	
17		179. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, интернетийн зохистой хэрэглээг бий болгох чиглэлээрх төрийн бодлого зорилтыг хэрэгжүүлэх, хяналт тавих			Цахим гарын үсэгтэй албан хаагчдын тоо 35 МАБ журмын хэрэгжилтийн хувь-80	хөрөнгө зарцуулаагүй	Төсвийн шинэчлэлтийн хүрээнд хийгдсэн төрийн байгууллагуудын цалин хөлсний гүйлгээг цахимаар хийх зорилтыг хэрэгжүүлэн соёл, урлагийн салбарын 18 байгууллагуудын дарга, нягтлан бодогчид нууцлал бүхий цахим системээр холбогдох гүйлгээнүүдийг хийж хэвшээд байна. Үндсэн хуульд заасан иргэний мэдэх эрх, хувь хүний нууцыг хуулиар хамгаалах үндсэн эрхийг баталгаажуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс албан хаагчдын ирцийн бүртгэлийг хурууны хээ уншуулж бүртгэхийг хориглосон ба тус газрын албан хаагчид ERP системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.Шинээр байгуулагдсан Соёл, урлагийн газар нь Юневишнны интернэт үйлчилгээг шинээр холбуулан албан хэрэгцээндээ ашиглаж байна. Салбарын хэмжээд цахим гарын үсэгтэй албан хаагчдын тоо-58 /Соёл, урлагийн газар 10 буюу 100%/	90%
18		181. Төр засаг, орон			Төрийн байгуул	Хөрөнгө зарцуулаагүй	Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор "Дорноговь аймгийн Соёл, урлагийн газар" нэртэй фэйсбүүк цахим	100%

		нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах, хүргэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх			ла-гын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээн ий тоо, цахим хаягтай болох сум, агентлагийн тоо 20	хуудсыг ашиглалтад оруулсан. Цахим хуудсаар дамжуулан соёлын салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцаж болно. Соёл, урлагийн газрын цахим хаяг 1454 гишүүнчлэлтэй байлантай оны хугацаанд нийт 43 нийтлэл оруулж, 15,785 хандалтыг авсан. Насны бүлгээр авч үзвэл 18-65 насны хэрэглэгчид цахим хаягийг дагадаг ба 25-44 насныхан илүү идэвхтэй хандалт хийж байна. Пэйж хуудасны дагагчдын 66,8% эмэгтэй, 33,2% эрэгтэйчүүд эзэлдэг. Нэгж байгууллагууд болон сумдын соёлын төвүүд бүгд фэйсбүүк цахим хаягтай ба үйл ажиллагааны мэдээ мэдээллээ цаг тухай бүрт иргэдэд хүргэж, олон нийтийн санал хүсэлтийг чөлөөтэй, эрх тэгш хүлээн авч байна. Соёл урлагийн газрын вэб болон пэйж хаяг Соёлын яамтай шууд холбогдсон. Мөн аймгийн тамгын газрын веб сайтнаас соёл, урлагийн газрын веб сайт руу шууд зочлох боломжтой. Соёл, урлагийн газар /do.moc.gov.mn/ Саран хөхөө театр /sarankhukhuu-theatre.mn/ веб сайтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Соёлын салбарын байгууллагууд мэдээллийн самбартаа иргэдэд зориулан албан хаагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, холбоо барих утас, и-мэйл хаяг, төсөв, санхүүгийн ил тод байдлыг байршуулан тухай бүр шинэчилдэг. Түүнчлэн соёлын салбарын санхүүгийн мэдээллийг сар бүрийн 8-ны дотор Shilendans.gov.mn цахим санд байршуулдаг.	
19	4.1.3. Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой тодорхойлж, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлнэ.	184. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, төр, иргэний хамтын ажиллагааны оновчтой арга хэрэгслийг нэвтрүүлэх			- Иргэдийн өргөдөл, гомдлын тоо, барагдуулалтын хувь 95% - төрийн байгууллагуудын талаарх иргэдээс авах судалгааны үр дүнг	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг үндэслэн "Соёл, урлагийн салбарын ёс зүйн зөвлөл"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус ёс зүйн зөвлөлийн дарга Б.Хүдэрчулуу, нарийн бичиг А.Наранжаргал нар нэгж байгууллага, сумдын Соёлын төвийн нийт 53 албан хаагчдад ёс зүйн цахим сургалтыг зохион байгууллаа. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг байгууллагын пэйж хуудсаар хүлээн авахаас гадна салбарын ёс зүйн зөвлөлийн албан хаагчдын холбогдох цахим хаяг, утасны дугаарыг ил тод байршуулан хүсэлтийг хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлант оны байдлаар нийт 16 өргөдөл, гомдол цаасаар ирсэн ба ажилд орох өргөдөл - 11 ажлаас чөлөөлөгдөх хүсэлт - 3 Салбарын албан хаагчтай холбоотой гомдол - 1 Сургалтын төлбөрийн хүсэлт -1 ирсэн ба 16-аас 15 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн ба 1 хүсэлт хүлээгдэж байна. Өргөдөл гомдол барагдуулалтын хувь: 94% 2. Зөвлөн туслах баг Замын-Үүд, Зүүнбаян, Иххэт, Даланжаргалан, Айраг, Өргөн сумдад ажиллах явцдаа Соёлын төвийн үйл ажиллагааны талаар 112 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч боловсруулан, дүгнэлтийг харгалзан зөвлөмж хүргүүлсэн.	90%

					тооцсон байна. - ТББ-аар гүйцэтгүүлэх ажлын тоо-7			
20	4.1.4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.	186. Төрийн байгууллагын хүний нөөцийн аудитыг хийж, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100	“Соёл, урлагийн ажилтны өдөр-Соёлын орон зай” зөвлөгөөнд 10 сая төгрөг зарцуулсан	Соёл, урлагийн газар нь Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар баталсан зохион байгуулалтын бүтцийн дагуу 11 орон тоотой ба одоогоор 10 албан хаагч ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолт Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 8 сарын 31-ний өдрийн 553 дугаар тогтоолоор батлагдсан ба хуулийн хугацааны дагуу 6 сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлсэн. Салбарын хэмжээнд хүний нөөцийн суурь судалгааг хийж, 214 албан хаагчдын мэргэшсэн байдалд судалгаа хийхэд 50 орчим хувийн үзүүлэлт гарсан бөгөөд уг хувийг өсгөх, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэхээр ажиллаж байна. Соёлын яам болон аймаг орон нутгаас соёлын талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг орон нутгийн соёлын ажилтнуудад танилцуулах зорилгоор “Соёл, урлагийн ажилтны өдөр-Соёлын орон зай” зөвлөгөөнийг Сайншанд хотноо 14 сумын соёлын ажилтан, Саран хөхөө театр, Төв номын сан, Музей сургалт судалгааны төвийн нийт 200 гаруй ажилтан, уран бүтээлчдийг хамруулан зохион байгууллаа. Зөвлөгөөнд Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Т.Ууганбаяр, Соёлын өвийн газрын ахлах Доктор Д.Мэндсайхан, СУИС-ийн Хөгжлийн хорооны дарга Доктор, Дэд профессор Ж.Эрхэмтөгс СУГ-ын дарга У.Ганбаатар нарын илтгэл, мэдээллүүд явагдаж, орон нутгийн болон соёлын яамны бодлого үйл ажиллагаа, соёлын салбарын төсвийн шинэтгэл, боловсон хүчнийг чадавхжуулах, бэлтгэх талаар холбогдох мэдээлэл өгч соёлын ажилтнуудын санал бодлыг сонсож хэлэлцүүлэг өрнүүллээ. Соёл, урлагийн газрын дарга Аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор мэргэжилтэн солилцоогоор сумдын номын санчдын шинэлэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэхээр “Зочин номын санч” арга хэмжээг зохион байгуулж сумдын Соёлын төвийн 13 номын санчдыг сэлгэн ажиллуулж, туршлага, арга зүйг судлууллаа.	100%
21		187. Төрийн албан хаагчийн харилцаа			Зохион байгуулах ажлын тоо 4		Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг албан хаагчдад танилцуулан, өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллахаас гадна уг тогтоолыг үндэслэн Соёл, урлагийн салбарын Ёс зүйн зөвлөлийг 5 хүний	100%

		хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, шинэ соёлыг төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэх				бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус зөвлөлөөс Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор салбарын албан хаагчдын дунд "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж 53 албан хаагч хамрагдлаа. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" тогтоол болон Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ний "Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай" 01 дугаарын албан даалгаврыг үйл Соёлын салбарын ёс зүйн зөвлөлөөс салбарын албан хаагчдад ёс зүйн мэдлэг олгох зорилгоор Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг постер хэлбэрээр цахимаар танилцуулан ажилласан. ХШҮ-ний мэргэжилтэн "Удирдлагын академи"-аас зохион байгуулсан "Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь" сэдэвт богино хугацааны 20 цагийн зайн сургалтад, Соёл, гэгээрлийн мэргэжилтэн Соёлын яамнаас зохион байгуулсан "Ёс зүйн зөрүү ойлголт" сэдэвт цахим сургалтад хамрагдаж сургалтаар олж авсан мэдлэгээ бусдадаа хуваалцсан.		
22		188. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэшүүлж, чадавхжуулах тогтолцоог хөгжүүлэн хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх			Нийгмийн баталгаа, сургалтын орчныг сайжруулах хувь 70% Сургалтад хамрагдах албан хаагчийн хувь 90	Байгууллагын тавилга эд хогшилд: Соёлын Яам 4,1 сая ОНТ 31,4 сая	Байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг байгууллагын даргын 2022.04.30-ны өдрийн А/03 тушаалаар батлуулсан. Албан хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Соёлын яамнаас 4,104,500 төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшил, АЗД-ын А/57 дугаарын захирамжаар орон нутгийн нөөц хөрөнгөөс 19,035,900 төгрөг, Төсвийн чөлөөт үлдэгдлээс 12,443,100 төгрөгийн дэмжлэг үзүүлж нийт 31,479,000 төгрөгийн тавилгыг худалдан авч ая тухтай орчныг бүрдүүлсэн. Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор Аймгийн нэгдсэн эмнэлэгт "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо"-нд 9 албан хаагчийг хамрууллаа. Мөн тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах, 7 хоногт 3 удаа нийтийн бүжгээр хичээллэх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Тайлант хугацаанд Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/233 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалт, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөө"-тэй уялдуулан орон нутаг болон байгууллагын хэмжээнд сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг 100 хувь хамруулж, ур чадвар мэдлэгээ дээшлүүлэн ажиллав.	100%

23	4.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цар хүрээг нэмэгдүүлж, төрийн байгууллагын ажлын үр дүнг сайжруулна.	208. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг нэмэгдүүлж, дээд шатны байгууллагын үнэлгээний хувийг ахиулах			Үнэлгээний хувь 88.0	Хөрөнгө зарцуулаагүй.	Салбарын ХШҮ-ний мэдээллийн цахим сан /www.moc.igovernment.mn/ болон Дорноговь аймгийн ХШҮ-ний мэдээллийн цахим санд /www.dornogovi.unelgee.gov.mn/ нэвтэрч, бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнан, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан /https://plan.igovernment.mn/home/-д байгууллагын 10 албан хаагчийг албан хэргийн мэйл хаягаар холбон нэвтрүүлсэн ба Соёлын яам болон Ухаалаг засаглал ТББ-аас хөгжүүлэлтийн шатандаа явагдаж байна. Салбарын ХШҮ-ний мэдээллийн цахим сан болон Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг хэрхэн ашиглах талаар Соёлын Яам, Ухаалаг Засаглал ТББ-ын хамтарсан 2 удаагийн цахим сургалтад хамрагдсан. АЗДТГ-ын ХШҮДАХ-ээс зохион байгуулсан ХШҮ-ний албан хаагчдыг чадавхжуулах сургалтад байгууллагын 2 албан хаагч хамрагдаж төрийн болон орон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, үнэн зөв бодитой тайлагнах арга зүй болон үр дүнд суурилсан хяналт шинжилгээ хийх талаар мэдлэгтэй болсон. Айраг, Даланжаргалан, Иххэт, Замын-Үүд, Зүүнбаян, Мандах, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ сумдын Соёлын төв болон Төв номын сан зэрэг 2022 оны 11 сарын байдлаар салбарын нийт 10 байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах баг ажилласан ба төлөвлөлт, тайлагналт, албан хэрэг хөтлөлт зэрэгтэй танилцаж, зөвлөгөө өгч, гарсан зөрчил дутагдлыг танилцуулан зөвлөмж хүргүүлж ажилласан. ХШҮ-ний мэргэжилтэн А.Наранжаргал салбарын албан хаагчдад "Тайлан бичих арга зүй" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 31 албан хаагч хамрагдлаа. Уг сургалтаар тайлангийн бүтэц болон тайланд анхаарах зүйлсийн талаар мэдээлэл хүргэсэн. Тайлант оны эхний хагас жилийн тайлангуудад хяналт-шинжилгээ хийж, сүүлийн хагас жилд эрчимжүүлэх, сайжруулах шаардлагатай зорилт арга хэмжээ болон тайлан бичихэд анхаарах зүйлсийг зөвлөмж хэлбэрээр байгууллагын албан хаагчид болон 3 нэгж байгууллагад хүргүүлж ажиллалаа.	100%
----	--	---	--	--	----------------------	-----------------------	--	------

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:  
СОЁЛ, УРЛАГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ХҮДЭРЧУЛУУ

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ,  
ЦАХИМЖИЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.ХАНДДОРЖ